

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1 Аудитын ГЭРЧИЛГЭЭ.....	2
2 Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Зорилтод түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3 Менежментийн захидал.....	9
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
МАЙНИНГ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.НАРАНХҮҮ
ТАНАА

2020.03.13 № 06/790
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Эрдэнэс Тавантолгой майнинг ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал Х.Наранхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн харилцах дансны үлдэгдэлд бодогдох хүүгийн орлогыг Голомт банкт хийсэн гэрээний дагуу тооцож байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлаж түрээсийн байраа сонгож байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс 3 дугаар сарын 10-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Конфиденсе Аудит” ХХК-ийн П.Ариунаа ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 113 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрхэм зорилго:

"Эрдэнэс тавантолгой майнинг" ХХК нь таван толгой ордын МҮ-011943 дугаар бүхий Цанхийн зүүн хэсгийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшин олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа явуулах бөгөөд компанийн хувьцааны 30 хүртэлх хувийг олон улсын хөрөнгийн бирж дээр арилжаалж нээлттэй компанийн хэлбэрээр ажиллах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр "Эрдэнэс тавантолгой майнинг" ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ашигт малтмалын ашиглалт үйл ажиллагаа;
- Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
- Ложистикийн үйл ажиллагаа, гаалийн хяналтын бүсэд бүтээгдэхүүн хадгалах, ачиж буулгах, тээвэрлэх;
- Тусгай зөвшөөрлөөр олгогдсон газрыг түшиглэн ашигт малтмал баяжуулах үйлдвэр, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр барих, уул уурхайн болон аж үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүнийг дотоод, гадаад дотоодын зах зээлд борлуулах;
- Компани нь үйл ажиллагааны чиглэлдээ нийцсэн ашиг орлогоо нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлж болно.

“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн охин компанийн хэлбэрээр, 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан.

"Эрдэнэс тавантолгой майнинг" ХХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Эрдэнэс тавантолгой майнинг" ХХК-ийн удирдлага дараах хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Эрдэнэс тавантолгой майнинг" ХХК нь "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шууд ашиглахаар шийдвэрлэсэн ба энэ нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

"Эрдэнэс тавантолгой майнинг" ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Эрдэнэс тавантолгой майнинг" ХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Би Ти солюшн ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Силикон 3.0 санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

"Эрдэнэс тавантолгой майнинг" ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад "Эрдэнэс тавантолгой майнинг" ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны Нийт хөрөнгө 29,610.3 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 296.1 сая төгрөгөөр төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан бөгөөд гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг хэвээр үлдээв.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны байдлаар жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,310.3 сая төгрөгөөр өссөн. Материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, богино хугацаат өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	/сая төгрөг/ Өөрчлөлт 3=2-1
			Мөнгөн хөрөнгө
Авлага	0.0	1.7	1.7
Урьдчилж гарсан зардал	0.0	5,529.0	5,529.0
Бараа материал	0.0	24.9	24.9
Үндсэн хөрөнгө	0.0	9.0	9.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	0.0	154.8	154.8
Нийт хөрөнгө	300.0	29,610.3	29,310.3
Богино хугацаат өр төлбөр	0.0	28,247.2	28,247.2
Урт хугацаат өр төлбөр	0.0	154.8	154.8
Өмч	300.0	2,852.8	2,552.8
Хуримтлагдсан ашиг	0.0	-1,644.5	-1,644.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	300.0	29,610.3	29,310.3

Урьдчилж гарсан зардал нь IPO гаргахтай холбоотой гадаад, дотоодын 4 байгууллагаас нийт 5 төрлийн зөвлөх үйлчилгээ авахтай холбоотой 5,521.3 сая төгрөгийн гэрээний урьдчилгаа төлбөр төлсөн байна.

Богино хугацаат өр төлбөрийн өсөлт нь үйл ажиллагаа эхлүүлэхтэй холбогдон толгой компаниас зээлсэн санхүүжилтийн 26,400.0 сая төгрөг байна.

2.9. ЗОРИЛТОД ТҮВШИН, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Толгой компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлж явуулахад шаардлагатай зарим зардлыг эхний ээлжинд санхүүжүүлэх зорилгоор 2019 оны зардлын төсвийг 2,552.8 сая төгрөгөөр баталсан ба батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 27 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 94.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 94.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Толгой компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод сайжруулалт хийхээр PWC ХХК гэрээ хийн ажиллаж байна. Ирэх онд бүртгэлийн бодлогод нэлээд их өөрчлөлт орох магадлалтай байгаа тул тус өөрчлөлтийг анхаарч ажиллах шаардлагатай.

2.12. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудсанд байршуулах 7 төрлийн 37 мэдээллийг бүрэн байршуулсан байна. Тайлант онд цахим санд жилд нэг удаа оруулах 2 мэдээллээс нэгийг нь хугацаа хоцроож оруулсан. Сар бүр оруулах 35 мэдээллээс 30-ыг нь хугацаа хоцроож оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

“Эрдэнэс тавантолгой майнинг ХХК нь 2019 онд байгуулагдаж анхны тайлангаа бэлтгэж байна. Иймээс өмнөх үеийн зөвлөмж байхгүй.

2.14. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй санал дүгнэлт”

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБООС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1.ХАРИЛЦАХ ДАНСАНД МӨНГӨН ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТ ХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1. Илрүүлэлт:

Харилцах данс нээснээс хойш дансны үлдэгдэлд 162.3 сая төгрөгийн хүү бодогдсон байна. Банк хүүг тооцоолохдоо тухайн сарын хамгийн бага үлдэгдэлтэй өдрийн үлдэгдлийг хүү бодох сарын суурь болгож ашигласан ба сарын хүү 3 хувь байна. Голомт банктай байгуулсан гэрээг уншиж үзэхэд тус гэрээний хүү тооцох заалт нь тодорхой бус ойлгомжгүй, гэрээг байгуулахдаа хариуцлагагүй хандсан байна.

Голомт банк гэрээнд байгаа тодорхой бус заалтуудаас хамгийн бага хүү төлөх нөхцөлийг ашиглаж хүүг бодож болгосон байна.

Аудитор өдрийн үлдэгдэлд хүүг тооцоолж бодоход 209.3 сая төгрөгийн хүү бодогдохоор, Толгой компани болох “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Голомт банктай байгуулсан гэрээний нөхцөлөөр бодож үзэхэд 255.8 сая төгрөгийн хүү тооцоологдож байгаагаас харахад багадаа 47.0 сая төгрөгийн хүүгийн орлого олох боломж алдсан байна.

3.1.2. Эрсдэл:

Мөнгөний менежментийг хийхгүй байснаас нэмэлт орлого олох боломжоо алдаж байна.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

1. Голомт банктай хийсэн гэрээг шинэчилж, хүү тооцох нөхцөлөө тодорхой болгох
2. Цаашид орлого олж мөнгөний урсгал нэмэгдэх тул мөнгөн хөрөнгийн менежмент хийх талаар арга хэмжээ авч ажиллаж холбогдох алба хэлтсүүдэд үүрэг болгох.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Түрээсийн гэрээтэй холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

2019 оны 11, 12-р сард түрээсийн зардалд 88.1 сая төгрөг төлсөн. Түрээсийн гэрээнд 1м.кв талбайг 65.0 мянган төгрөгөөр түрээслэхээр заасан. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 01 дугаартай хуралдааны тэмдэглэлд заасан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн 1м.кв талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг 30.0 мянган төгрөгөөс ихгүй байлгах”, “Түрээсийн үйлчилгээний гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй сонгон шалгаруулах”, “Бусдаас байр талбай түрээслэх бол ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч байх” гэсэн заалтууд болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй байна.

Компанийн удирдлагын зүгээс бид энэ хуулийн 3.10-д заасны дагуу тендер зарлахаас чөлөөлөгдсөн, олон улсад IPO зарласан Монгол улсын нүүр царайг харуулах үндэсний компани учраас зэрэглэл өндөртэй оффис түрээслэх хэрэгтэй, мөн компани байгуулагдаад удаагүй, ажилчдад тавилга эд хогшил худалдан аваагүй байсан учраас тавилгатай оффис түрээсэлсэн гэж тайлбарласан.

3.2.1 Эрсдэл

Төрийн өмчийн хорооны 2018 оны 1-р сарын 9-ний өдрийн 01 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг хэрэгжихгүй, хөрөнгө үр ашиггүй зарцуулсан байх эрсдэлтэй.

3.2.3 Зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлаж түрээсийн байраа сонгох шаардлагатай байна.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

3.3.1 Илрүүлэлт

Тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд жилд нэг удаа оруулах 2 мэдээллээс нэгийг нь, сар бүр оруулах 35 мэдээллээс 30-ыг нь тус тус хугацаа хоцроож оруулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг тогтмол мэдээлнэ заалтыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл

Шилэн дансны хуулийн 1-д заасан “улсын өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор үйл ажиллагаа ил тод нээлттэй байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх” гэсэн үндсэн зорилтыг хэрэгжүүлэхгүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг хугацаанд нь байршуулж хэвших

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 08-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	300,000,000.00	23,890,872,777.50
1.1.2	Дансны авлага	-	88,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	1,643,272.92
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	-	24,895,793.69
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	5,528,995,420.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	300,000,000.00	29,446,495,264.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	-	708,308.38
1.2.2	Биет бус хөрөнгө	-	8,269,589.04
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	154,874,873.81
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	163,852,771.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	300,000,000.00	29,610,348,035.34
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	27,926,106,928.79
2.1.1.2	Цалингийн өглөг	-	162,503,603.51
2.1.1.3	Татварын өр	-	154,704,609.38
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	3,852,929.97

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	28,247,168,071.65
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	154,874,873.81
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	154,874,873.81
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	28,402,042,945.46
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	300,000,000.00	2,852,800,000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	(1,644,494,910.12)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	300,000,000.00	1,208,305,089.88
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	300,000,000.00	29,610,348,035.34

4.2. Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2019 оны 08-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг(алдагдал)	-	-
Түрээсийн орлого	-	-
Хүүгийн орлого	-	162,295,404.42
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	-	99,000.00
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	-	1,728,388,217.21
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	-	59,877,494.08
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	(2,394,062.82)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	(1,628,265,369.68)
Орлогын татварын зардал	-	16,229,540.44
Татварын дараах ашиг (алдагдал)	-	(1,644,494,910.12)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(1,644,494,910.12)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	
Бусад олз (гарз)	-	
Орлогын нийт дүн		
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3. Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 1-р сарын 01-ний үлдэгдэл	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
9	2019 оны 08 -р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	-	300,000,000.00
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(1,644,494,910.12)	(1,644,494,910.12)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	2,552,800,000.00	-	2,552,800,000.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
17	2019 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,852,800,000.00	(1,644,494,910.12)	1,208,305,089.88

4.4. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 08-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	99,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	99,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	5,514,811,114.93
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	746,172,858.33
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	228,644,125.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	51,573,482.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	797,461.56
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	403,388,727.83
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	4,084,234,459.26
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(5,514,712,114.93)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	162,295,404.42
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	162,295,404.42
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	9,512,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	712,800.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	8,800,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6			

“Эрдэнэс тавантолгой майнинг” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	152,782,604.42
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	28,952,800,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	26,400,000,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	2,552,800,000.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	28,952,800,000.00
4	Валютын ханшийн зөрүү	-	2,288.01
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	23,590,872,777.50
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	300,000,000.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	300,000,000.00	23,890,872,777.50

4.5. Аудит хийсэн Зорилтот түвшин, гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүн	Хувь
1	Цалингийн зардал	1,094,670,000.00	1,033,224,106.25	(61,445,893.75)	94%
2	Түрээсийн зардал	144,000,000.00	109,488,751.82	(34,511,248.18)	76%
3	Харилцаа, холбооны зардал	45,600,000.00	18,395,529.91	(27,204,470.09)	40%
4	Уулзалтын зардал	60,000,000.00	59,549,014.10	(450,985.90)	99%
5	Бичиг хэргийн зардал	48,000,000.00	11,064,784.31	(36,935,215.69)	23%
6	Ариун цэвэр, ахуйн зардал	10,500,000.00	3,161,640.00	(7,338,360.00)	30%
7	Түлш, шатахууны зардал	18,000,000.00	-	(18,000,000.00)	0%
8	Томилолтын зардал	750,000,000.00	268,055,099.73	(481,944,900.27)	36%
9	Татвар, зөвшөөрөл, хураамжийн зардал	150,000,000.00	150,220,804.71	220,804.71	100%
10	Магадлашгүй зардал /10%/	232,050,000.00	123,054,481.65	(108,995,518.35)	53%
	Нийт дүн	2,552,820,000.00	1,776,214,212.48	(776,605,787.52)	5.52

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Огноо:

**2019
он**

Аудитын
нэр:

**Санхүүгийн
тайлангийн
аудит**

САГ-2020/117/14-ТӨҮГ

Шалгагдсан
байгууллагын

**Эрдэнэс тавантолгой
майнинг ХХК**

сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Голомт банкны харилцах дансны үлдэгдэлд хүү тооцох гэрээг байгуулахдаа хариуцлагагүй хандаж бага хүүтэй нөхцөлийг зөвшөөрсөн	47.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Х.Наранхүү
2	Түрээсийн зардлыг ТӨБЗ-н 2008 оны 1 дүгээр сарын 09 өдрийн 01 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн чиглэлийг мөрдөж ажиллаагүй	47.4	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Х.Наранхүү
3	Шилэн дансны тухай 6 дугаар зүйлийн 6.1,6.4 –р заалтыг мөрдөж ажиллаагүй		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Х.Наранхүү
Дүн		94.4			

